

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/080/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 99389927 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/183
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ДОГСМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,309,014.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 1,081,772.4 мянган төгрөгийн санхүүжилт авч үлдэгдэл 225,410.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь хөргөлж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 98,224.8 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчлийг илрүүлснээс аудитын хугацаанд 81,820.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 3,118.0 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж, 13,286.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

673022084

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн слон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 89.5 хувьтай дүгнэсэн байна.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/ төгрөгөөр /	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>163,906,315.17</u>	<u>378,041,298.57</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,957,261.63	35,252,725.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,957,261.63	35,252,725.84
3121	Төгрөг	30,957,261.63	35,252,725.84
31211	Төрийн сангийн харилцах	30,957,261.63	35,252,725.84
33	АВЛАГА	23,649,105.76	225,439,200.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,100.76	29,100.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	23,620,005.00	225,410,099.47
35	БАРАА МАТЕРИАЛ	109,299,947.78	117,349,372.50
351	Түүхий эд материал	44,839,813.82	43,867,907.58
35130	Эм боох материал	44,839,813.82	43,867,907.58
354	Хангамжийн материал	64,460,133.96	73,481,464.92
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	17,561,020.00	20,611,522.46
35430	Сэлбэг хэрэгсэл	1,348,100.00	1,500,000.00
35440	Түлш, шатах тослох материал		846,080.00
35450	Барилгын засварын материал	202,890.00	202,890.00
35460	Хүнсний материал	15,116,942.50	13,566,446.00
35470	Бусад хангамжийн материал	30,031,181.46	36,754,526.46
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,906,112,617.95</u>	<u>1,857,672,907.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,906,112,617.95	1,857,672,907.46
392	Биет хөрөнгө	1,884,952,617.91	1,835,350,907.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,615,871,546.28	1,615,871,546.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(179,042,147.40)	(217,260,704.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,012,896.55	67,921,714.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,970,129.91)	(46,804,004.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	545,155,128.01	587,247,618.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(209,371,766.45)	(272,539,904.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,003,800.00	79,275,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,446,562.04)	(20,666,984.70)
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,306,459.80	62,306,459.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,566,606.93)	(20,000,232.65)
393	Биет бус хөрөнгө	21,160,000.04	22,322,000.08
39301	Програм хангамж	1,690,000.00	1,690,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,337,999.96)	(175,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,808,000.00	20,808,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,070,018,933.12</u>	<u>2,235,714,206.03</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,324,079.21</u>	<u>30,577,985.71</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,324,079.21	30,577,985.71
413	Өглөг	3,324,079.21	30,577,985.71
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,324,079.21	30,577,985.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,066,694,853.91</u>	<u>2,205,136,220.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,066,694,853.91	2,205,136,220.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	435,284,554.00	435,284,554.00
51101	Өмч: - төрийн	435,284,554.00	435,284,554.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,541,990,118.21	1,680,796,209.61

51210	Өмнөх үеийн үр дүн	1,541,990,118.21	1,542,354,843.20
51220	Тайлант үеийн үр дүн		138,441,366.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,420,181.70	89,055,456.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,070,018,933.12	2,235,714,206.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	921,415,810.70	1,549,017,880.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,622,510.58	192,616,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,622,510.58	192,616,220.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	105,602,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,602,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	861,793,300.12	1,356,401,660.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,839,200.00	72,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,839,200.00	72,839,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	788,954,100.12	1,283,562,460.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	788,954,100.12	1,283,562,460.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,053,391,009.02	1,410,576,513.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,053,391,009.02	1,410,576,513.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,052,582,467.02	1,334,601,671.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,926,726.87	843,264,491.52
210101	Үндсэн цалин	351,153,184.10	485,812,591.29
210102	Нэмэгдэл	153,354,896.94	296,218,010.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,076,126.25	14,404,000.00
210104	Урамшуулал	58,342,519.58	46,829,889.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,302,968.00	127,934,200.00
210201	Тэтгэврийн даатгал	47,867,184.00	94,193,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,275,571.00	8,435,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,190,337.00	4,217,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,118,733.00	4,217,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,851,143.00	16,870,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,030,658.00	64,111,058.00
210301	Гэрэл, цахилгаан	4,848,930.00	5,403,670.00
210302	Түлш, халаалт	60,148,728.00	56,742,000.00
210303	Цэвэр, бохир ус	33,000.00	1,965,388.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,913,264.62	42,910,900.00
210401	Бичиг хэрэг	4,407,960.00	4,310,700.00
210402	Тээвэр, шатахуун	21,541,646.00	20,752,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,080,000.00	1,938,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,827,218.03	15,908,920.00
210408	Бараа материал акталсны зардал	22,056,440.59	00.00
2105	Нормативт зардал	100,551,129.26	100,774,687.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,390,197.26	90,032,391.28
210502	Хоол, хүнс	16,160,932.00	10,742,296.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,807,000.00	9,036,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,894,000.00	5,200,000.00
210604	Урсгал засвар	4,913,000.00	3,836,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,125,000.00	1,893,000.00
210702	Дотоод албан томилолт	1,125,000.00	1,893,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,037,050.00	3,085,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,436,300.00	1,538,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,000.00	36,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,750.00	31,450.00
210807	Газрын төлбөр	208,000.00	207,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,888,670.27	141,591,484.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,234,200.00	1,338,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	155,654,470.27	140,253,484.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	808,542.00	75,974,842.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	73,602,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	73,602,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	808,542.00	2,372,842.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	808,542.00	2,372,842.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(131,975,198.32)	138,441,366.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(131,975,198.32)	138,441,366.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	838,173,295.12	1,260,213,565.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	105,602,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	105,602,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	105,602,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,602,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,173,295.12	1,154,611,565.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,839,200.00	72,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,839,200.00	72,839,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	765,334,095.12	1,081,772,365.73
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	765,334,095.12	1,081,772,365.73
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	839,282,150.87	1,226,278,101.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	839,282,150.87	1,226,278,101.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	838,473,608.87	1,150,303,259.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,926,726.87	843,264,491.52
210101	Үндсэн цалин	351,153,184.10	485,812,591.29
210102	Нэмэгдэл	153,354,896.94	296,218,010.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,076,126.25	14,404,000.00
210104	Урамшуулал	58,342,519.58	46,829,889.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,319,468.00	127,934,200.00
210201	Тэтгэврийн даатгал	47,867,184.00	94,193,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,275,571.00	8,435,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,190,337.00	4,217,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,135,233.00	4,217,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,851,143.00	16,870,700.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,030,658.00	64,111,058.00
210301	Гэрэл, цахилгаан	4,848,930.00	5,403,670.00
210302	Түлш, халаалт	60,148,728.00	56,742,000.00
210303	Цэвэр, бохир ус	33,000.00	1,965,388.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,358,546.00	29,866,960.00
210401	Бичиг хэрэг	2,475,000.00	2,109,900.00
210402	Тээвэр, шатахуун	18,310,846.00	21,598,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,080,000.00	1,938,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	1,550,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,742,700.00	2,668,900.00
2105	Нормативт зардал	77,033,800.00	57,718,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,750,400.00	45,726,900.00
210502	Хоол, хүнс	9,647,400.00	9,191,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,636,000.00	2,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,099,700.00	15,517,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,249,700.00	5,200,000.00
210604	Урсгал засвар	4,850,000.00	10,017,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,125,000.00	1,893,000.00
210702	Дотоод албан томилолт	1,125,000.00	1,893,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,198,710.00	5,086,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,197,660.00	1,538,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,000.00	36,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,750.00	31,450.00
210807	Газрын төлбөр	208,000.00	207,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,400,300.00	2,000,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,381,000.00	4,911,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,381,000.00	4,911,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	808,542.00	75,974,842.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	73,602,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	73,602,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	808,542.00	2,372,842.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	808,542.00	2,372,842.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-1,108,855.75	33,935,464.21
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,399,700.00	29,640,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,399,700.00	29,640,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,399,700.00	29,640,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,399,700.00	29,640,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,399,700.00)	(29,640,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-8,508,555.75	4,295,464.21
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,465,817.38	30,957,261.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,957,261.63	35,252,725.84

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,541,990,118.21	2,066,694,853.91
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,541,990,118.21	2,066,694,853.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			364,724.99	364,724.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,284,554.00	89,420,181.70	1,542,354,843.20	2,067,059,578.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-364,724.99		(364,724.99)
Тайлант үеийн үр дүн			138,441,366.41	138,441,366.41
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,055,456.71	1,680,796,209.61	2,205,136,220.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,218,362,500.00	1,183,078,901.52	97.1	35,283,598.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,218,362,500.00	1,183,078,901.52	97.1	35,283,598.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,432,500.00	1,109,476,901.52	98.1	21,955,598.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,531,500.00	843,264,491.52	99.97	267,008.5
210101	Үндсэн цалин	477,736,100.00	485,812,591.29	101.69	(8,076,491.3)
210102	Нэмэгдэл	309,634,700.00	296,218,010.49	95.67	13,416,689.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,100,000.00	14,404,000.00	109.95	(1,304,000.00)
210104	Урамшуулал	43,060,700.00	46,829,889.74	108.75	(3,769,189.74)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,934,200.00	127,934,200.00	100.00	
210201	Тэтгэврийн даатгал	94,193,000.00	94,193,000.00	100.00	
210202	Тэтгэмжийн даатгал	8,435,300.00	8,435,300.00	100.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,217,600.00	4,217,600.00	100.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	4,217,600.00	4,217,600.00	100.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	16,870,700.00	16,870,700.00	100.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	30,529,500.00	29,866,960.00	97.83	662,540.00
210401	Бичиг хэрэг	2,133,100.00	2,109,900.00	98.91	23,200.00
210402	Тээвэр, шатахуун	21,842,600.00	21,598,460.00	98.88	244,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,938,900.00	1,938,900.00	100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,615,200.00	1,550,800.00	96.01	64,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,700.00	2,668,900.00	88.97	330,800.00
2105	Нормативт зардал	76,822,900.00	57,718,700.00	75.13	19,104,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,726,900.00	45,726,900.00	100.00	
210502	Хоол, хүнс	28,283,200.00	9,191,800.00	32.50	19,091,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,812,800.00	2,800,000.00	99.54	12,800.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,186,900.00	38,801,800.00	99.02	385,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	29,940,000.00	99.80	60,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,249,700.00	5,200,000.00	99.05	49,700.00
210604	Урсгал засвар	3,937,200.00	3,661,800.00	93.01	275,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,025,000.00	1,893,000.00	93.48	132,000.00
210702	Дотоод албан томилолт	2,025,000.00	1,893,000.00	93.48	132,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,996,700.00	5,086,150.00	84.82	910,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,006,400.00	1,538,000.00	76.65	468,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	100.00	
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00	100.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	36,000.00	30.00	84,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	31,450.00	62.90	18,550.00
210807	Газрын төлбөр	208,000.00	207,900.00	99.95	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,340,300.00	2,000,800.00	85.49	339,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5405800.00	4911600.00	90.86	494,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,405,800.00	4,911,600.00	90.86	494,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,930,000.00	73,602,000.00	84.67	13,328,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,930,000.00	73,602,000.00	84.67	13,328,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	86,930,000.00	73,602,000.00	84.67	13,328,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,218,362,500.00	1,187,374,365.73	97.46	30,988,134.27
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,099,432,500.00	1,081,772,365.73	99.13	17,660,134.27
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,099,432,500.00	1,081,772,365.73	99.13	17,660,134.27
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	118,930,000.00	105,602,000.00	88.79	13,328,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,930,000.00	105,602,000.00	88.79	13,328,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	30,957,261.63		(30,957,261.63)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	35,252,725.84		(35,252,725.84)

2.6 Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,839,200.00	70,466,358.00	2,372,842.00	96.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	72,839,200.00	70,466,358.00	2,372,842.00	96.7
210	Бараа, үйлчилгээний зардал	72,839,200.00	70,466,358.00	2,372,842.00	96.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,483,900.00	64,111,058.00	2,372,842.00	96.4
210301	Гэрэл цахилгаан	7,741,900.00	5,403,670.00	2,338,230.00	69.8

210302	Түлш, халаалт	56,742,000.00	56,742,000.00		100
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,965,388.00	34,612.00	98.3
2106	Эд хогшил худалдан авах	6,355,300.00	6,355,300.00		100
210604	Урсгал засвар	6,355,300.00	6,355,300.00		100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,839,200.00	70,466,358.0	2,372,842	96.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,839,200.00	70,466,358.0	2,372,842	96.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	72,839,200.00	70,466,358.0	2,372,842	96.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	72,839,200.00	70,466,358.0	2,372,842	96.7
132001	Орон нутгийн төсвөөс	72,839,200.00	70,466,358.0	2,372,842	96.7

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 98,224.8 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчлийг илрүүлснээс аудитын хугацаанд 81,820.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 3,118.0 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж, 13,286.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвийн төвлөрүүлэх шилжүүлгийн 2,372.8 мянган төгрөгийг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний журналд бүртгэж залруулсан.
- Үр дүнгийн тайланд системийн дээд байгууллагаас үнэ төлбөргүй хүлээж авсан орлогын дүнг 18,523.59 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул журналд бүртгэж залруулсан.
- Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй ирсэн 4,235.7 мянган төгрөгийн мотоцикль, 56,688.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн нь 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй тул үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө дансанд бүртгэж залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 16,404.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 449.6 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б. Догсмаа, мэс заслын эмч Б. Баярсайхан, шүдний эмч Н. Золжаргал нарын албан тушаалын үндсэн цалинг буруу тогтоосноос дээрх нэр бүхий эмч нарт нийт 13,286.6 мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, 2024 оны 128 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан цалингийн сүлжээг мөрдөөгүй,” үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв нь Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 онд баталсан Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2 дахь заалтыг хэрэгжүүлэх.

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төвийн томилолтын зардлаас хоолны хөнгөлөлт 237.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

3. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзэхгүй, зөвхөн Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар урамшуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэнэ...” заалтад нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Холбогдох, хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах.

1. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Шинэ-идэр сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын төсөвт ахмадын санг төлөвлөж тусгах, сан байгуулах

5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус Эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 62, зарлагын 20 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 11 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

6.Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2024 онд 1,325,038.7 мянган төгрөгийг нэхэмжилснээс 41,476.2 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвийн төвлөрүүлэх шилжүүлгийн 2,372.8 мянган төгрөгийг тайлагнаагүй	1	2,372.8	1	2,372.8			1	2,372.8		
Үр дүнгийн тайланд системийн дээд байгууллагаас үнэ төлбөргүй хүлээж авсан орлогын дүнг 18,523.59 төгрөгөөр илүү тайлагнасан	1	18,523.6			1	18,523.6	1	18,523.6		
Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй ирсэн 4,235.7 мянган төгрөгийн мотоцикль, 56,688.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг худалдан авсан	1	60,923.8			1	60,923.8	1	60,923.8		

хөрөнгөөр бүртгэсэн										
Дүн	3	81,820.2	1	2,372.8	2	79,447.4	3	81,820.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б. Догсмаа, мэс заслын эмч Б. Баярсайхан, шүдний эмч Н. Золжаргал нарын албан тушаалын цалинг буруу тогтоосон	1	13,286.6			1	13,286.6		
Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй	1	-					1	-
Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна.	1	237.0					1	237.0
Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгоходоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзахгүй, Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан.	1	2,881.0					1	2,881.0
Дүн	4	16,404.6			1	13,286.6	3	3,118.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая ба түүнээс дээш үнийн дүн бүхий орлогын 62 гүйлгээ, зарлагын 20 гүйлгээ, төсөв, санхүү, мөнгө, хөрөнгө зарцуулахтай холбоотой 11 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна	1	0					1	0
Шинэ-идэр сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй	1	0					1	0
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системээр үнэн зөв, бүрэн тайлагнаж чадаагүйгээс ЭМДС-аас санхүүжилтийг бүрэн авч чадаагүй,	1	0					0	0
Дүн	3	0					3	0



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 26 өдөр

№ 37/ААТОН69/

Мөрөн сум

2025-2025-рүү МН-аа. АУЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Догсмаа, мэс заслын эмч Б.Баярсайхан, шүдний эмч Н.Золжаргал нарын албан тушаалын үндсэн цалинг буруу тогтоож 13,286,600 (Арван гурван сая хоёр зуун наян зургаан мянга зургаан зуу) мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 2 дугаар хэвсрэлт, 2024 оны 128 дугаар тогтоолын 6 дугаар хэвсрэлтээр баталсан цалингийн сүлжээг мөрдөөгүй, "үнэлгээ ба хуваарилал" батламж мэдэгдлийг хангахгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Албан хаагчдын цалинг тогтоохдоо хүчин төгөлдөр мөрдөж буй цалингийн сүлжээг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэ-Идэр сумын Засаг дарга Ц. Ганбаатар, Эрүүл мэндийн төвийн дарга Б.Догсмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЭРДЭНЗБААТАР
АУДИТОР  Г.ИЧИНХОРЛОО



6724090532